

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ
2019.08.19 - 08.23

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: АНУ, БНХАУ хоорондын худалдааны маргааны асуудал даамжирч, АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд 4 дэх долоо хоногоо дараалан уналттай хаагдлаа.

Жижиглэнгийн худалдааны "Target", "Lowe's" болон "Home Depot" компаниудын ашиг шинжээчдийн таамгаас өндөр гарч, тус компаниудын хувьцааны ханш өсөн, тансаг хэрэглээний бараа бүтээгдэхүүний салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниудын хувьцааны ханшид эерэгээр нөлөөлжээ. Мөн урт хугацаат бондын өгөөж буурснаар ус, дулаан, цахилгаан хангамжийн болоод үл хөдлөх хөрөнгийн салбарын компаниудын хувьцаа өссөн үзүүлэлттэй байна.

Даваа гарагт БНХАУ-ын харилцаа холбооны технологийн "Huawei" компанийн эсрэг авсан хориг арга хэмжээний хэрэгжиж эхлэх хугацааг дахин 90 хоногоор хойшлуулсан талаар АНУ-ын Ерөнхийлөгчийн Тамгын газар мэдэгдэж, хөрөнгийн зах зээлийн индексүүд өсжээ.

Лхагва гарагт Холбооны нөөцийн сан мөнгөнийн бодлогыг уян хатан байлгана хэмээн мэдэгдэж, хөрөнгийн зах зээлд эерэгээр нөлөөлжээ.

Баасан гарагт БНХАУ-ын эрх баригчид АНУ-ын 75 тэрбум ам.долларын өртөг бүхий автомашин болон сэлбэг хэрэгслийн импортын татварыг нэмэх шийдвэр гаргасны хариуд АНУ 9-р сараас Хятадын 300 тэрбум ам.долларын бараа бүтээгдэхүүний татварыг 10 хувиар бус урьд нь төлөвлөсний дагуу 15 хувиар нэмэгдүүлэх бол 250 тэрбум ам.доллароор үнэлэгдэх үлдсэн бараа бүтээгдэхүүний татвар 10 дугаар сарын 1-нээс эхлэн 25 хувь биш харин 30 хувь байх болно гэж Дональд Трамп мэдэгджээ. Ингэснээр хөрөнгийн зах зээл огцом унасан байна.

Европ: Худалдааны маргааны асуудал даамжирсан хэдий ч Европын бүсийн хөрөнгийн зах зээлийн дийлэнх индексүүд өсөлт үзүүлээ.

Европын Холбоо АНУ-ын бараа бүтээгдэхүүнд дангаар гаалийн татвар ногдуулж, технологийн компаниудынхаа хөгжилд дэмжлэг үзүүлэх зорилготой эдийн засгийн хөтөлбөр боловсруулжээ. Хөтөлбөрт зааснаар, Европын комиссын даргаар сонгогдсон Урсула фон дер Ляйен 100 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалттай Европын сан байгуулан, Америк болон Хятадын технологийн аваргуудтай өрсөлдөх ажээ. Гэсэн хэдий ч энэхүү санал нь одоогоор хэлэлцэх шатандаа байгаа юм.

Итали улсын сайд нарын танхимын дарга ноён Джузеппе Конте огцрох хүсэлт гаргасны дараагаар тус улсын өр өсжээ. Тэрээр Италийн Дотоод хэргийн сайд бөгөөд эрх баригч хоёр намын нэг болох "Лиги" намын дарга Маттео Сальвини өөрийн эрх ашгийг Итали улсын эрх ашгаас урд тавьж байна хэмээн буруутгав.

"IHS Markit"-аас танилцуулсан худалдан авагч менежерийн нэгдсэн индекс ХБНГУ-ын аж үйлдвэр, үйлчилгээний захиалгын хэмжээ сүүлийн 6 жилд үзэгдээгүйгээр хурдан унаж байгааг харуулжээ. Тус улсын төв банк Германы эдийн засаг уналтанд орж магадгүй талаар мэдээлэв. Энэ оны 2-р улиралд ХБНГУ-ын эдийн засаг 0.1 хувиар буурчээ.

Япон: 2-р улиралд Япон улсын ДНБ 1.8 хувиар өслөө. Япон улсын эдийн засаг 3 улирал дараалан өсөлт үзүүлж байгаа хэдий ч олон улсын зах зээлд эрэлт муудаж байгаа нь эргээд эдийн засагт нөлөөлнө хэмээн шинжээчид үзэж байна.

БНХАУ: БНХАУ-ын хувьцаат компаниудын ашиг нэмэгдэж, тус улсын Ардын банк мөнгөний бодлогыг зөөлрүүлснээр хөрөнгийн зах зээл өсөлт үзүүлээ.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	19,522.19	-2.37% ▼
Dow Jones	АНУ	25,628.90	-0.99% ▼
S&P 500	АНУ	2,847.11	-1.44% ▼
Nasdaq	АНУ	7,751.77	-1.83% ▼
S&P/TSX	Канад	16,037.58	-0.69% ▼
FTSE 100	Их Британи	7,094.98	-0.31% ▼
S&P/ASX 200	Австрали	6,523.10	1.84% ▲
Nikkei 225	Япон	20,710.91	1.43% ▲
Hang Seng	Хонг Конг	26,179.33	1.73% ▲

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	111.45
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	100.41
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	99.66
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	109.55
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	104.15
DBM' 2023	USD	7.250%	102.25
TDBM' 2020	USD	9.375%	102.74
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.7505	99.78

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	2.140	-0.03 ▼
Libor 3M	2.144	0.01 ▲
Libor 6M	2.080	0.06 ▲
Libor 1YR	2.029	0.08 ▲
US 2YR Bond	1.459	-0.03 ▼
US 3YR Bond	1.384	-0.06 ▼
US 5YR Bond	1.352	-0.08 ▼
US 10YR Bond	1.480	-0.10 ▼

Валютын ханш /төг/

Валют	2019.08.23	Өөрчлөлт
USD	2,671.55	-0.05% ▼
CNY	376.98	-0.63% ▼
EUR	2,957.14	-0.18% ▼
RUB	40.71	0.59% ▲
KRW	2.21	0.00% -
JPY	25.05	-0.52% ▼
CAD	2,006.20	-0.11% ▼

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /spot/	USD/t oz.	1,526.96	0.89% ▲
Мөнгө /spot/	USD/t oz.	17.43	1.82% ▲
Зэс	USD/lb.	253.75	-2.22% ▼
Нүүрс	USD/MT	67.30	-1.10% ▼
WTI газрын тос	USD/bbl.	54.17	-1.28% ▼
Brent газрын тос	USD/bbl.	59.34	1.19% ▲

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2019. VII	7.70%
Бодлогын хүү	2019. VII	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2019. VII	10.99%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2019. VII	11.44%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2019. VII	4.98%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2019. VII	16.99%
Зээлийн дундаж хүү /валют/	2019. VII	10.75%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА


Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 38 компанийн 501.5 сая төгрөгийн 1,058,977 ширхэг хувьцаа арилжаалагдав.

“Хүрд” /HRD/ компанийн хувьцаа 15.00%-аар буюу хамгийн ихээр өсөж 4,279.0 төгрөгт хүрч хаагдсан бол “Фронтинер лэнд групп” /MDR/ компанийн хувьцаа 14.09%-аар буурч 189.0 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.


8-р сарын 23-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,499.8 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 19,522.19 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 2.37%-аар буурсан байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2019 он/



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	501.5
Зах зээлийн үнэлгээ	2,499,776.5

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	19522.19	-2.37% ▼
MSE I индекс	9,042.33	-1.99% ▼
MSE II индекс	7,820.33	-1.08% ▼

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
Ард санхүүгийн нэгдэл	154,237	211,848,412
Таван толгой	18,219	118,902,450
Говь	125,443	35,575,332
АПУ	41,658	21,885,767
Инвескор ББСБ	11,109	20,890,827

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Хүрд	4,279.00	15.00% ▲
Женко тур бюро	70.00	11.09% ▲
Могойн гол	7,990.00	6.53% ▲
Гермес центр	127.54	6.28% ▲
Монгол шевро	1,800.00	4.65% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Фронтинер лэнд групп	189.00	-14.09% ▼
Ард санхүүгийн нэгдэл	1,352.00	-9.81% ▼
БиДиСек	833.22	-7.42% ▼
Ремикон	26.00	-7.14% ▼
Талх чихэр	17,020.00	-5.44% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Ард Секюритиз	418,456,610
БиДиСек	249,628,722
Стандарт Инвестмент	87,322,516
Ти Ди Би Капитал	55,017,099
Голомт Капитал	30,102,537

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	520.00	553,374
Таван толгой	6,840.00	360,330
МИК Холдинг	13,700.00	283,718
Говь	277.82	216,731
Инвескор ББСБ	1,909.00	136,929

ЗГҮЦ-НЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
---	-----------------	--------------------	-----------------	------------	------------	---------	-----

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	Симбол	Компанийн нэр	2018 оны цэвэр ашиг /сая төг/	Нийт хуваарилах ногдол ашиг /сая төг/	Ногдол ашиг төлөлтийн харьцаа	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	HRM	Гермес центр ХК	783.4	298.5	38.1%	3.8	2019.01.25	2019.02.18	2019.03.18-нд олгов
2	LEND	ЛэндМН ББСБ	2,560.3	800.0	31.2%	1.0	2019.01.30	2019.02.22	2019.03.28-нд олгов
3	MBW	Монгол Базальт ХК	217.2	56.4	26.0%	1.0	2019.02.01	2019.03.25	2019.06.14-нд олгов
4	BTG	Баянтээг ХК	1,771.4	1,000.0	56.5%	3,958.7	2019.02.11	2019.03.04	2019.06.01-с
5	SUL	Жуулчин дүти фрий ХК	1,384.5	653.6	47.2%	10,000.0	2019.02.12	2019.04.10	2019.05.31-с
6	GOV	Говь ХК	17,764.2	5,304.8	29.9%	6.8	2019.02.13	2019.03.28	2019.04.25-с
7	ADU	Хөвсгөл алтан дуулга ХК	399.2	1,888.1	473.0%	120.0	2019.02.13	2019.04.01	2019.05.01-с
8	TCK	Талх чихэр ХК	1,975.9	204.7	10.4%	200.0	2019.02.14	2019.04.03	2019.07.01-с
9	MMX	Мах импекс ХК	778.6	456.1	58.6%	120.0	2019.02.14	2019.04.03	2019.10.01-с
10	BUK	УБ-БҮК ХК	566.4	131.5	23.2%	1.0	2019.02.14	2019.04.05	2019.05.01-с
11	ТАН	Тахь-ко ХК	799.1	128.5	16.1%	108.0	2019.02.15	2019.04.05	2019.04.24-нд олгов
12	BNG	Баянгол зочид буудал ХК	3,433.1	150.2	4.4%	355.0	2019.02.16	2019.04.05	2019.09.01-с
13	MNP	Монгол шуудан ХК	1,560.3	468.1	30.0%	4.7	2019.02.18	2019.04.05	2019.05.01-с
14	HRD	Хүрд ХК	751.1	74.4	9.9%	550.0	2019.02.18	2019.03.04	2019.06.01-ний дотор
15	MNDL	Мандал даатгал ХК	3,868.3	624.3	16.1%	100.0	2019.02.18	2019.04.10	2019.05.27-нд олгов
16	GTL	Гутал ХК	2,225.8	1,257.7	56.5%	777.0	2019.02.18	2019.03.13	2019.05.06-с
17	TEX	Техник импорт ХК	2,702.0	723.4	26.8%	500.0	2019.02.18	2019.03.11	2019.04.11-с
18	APU	АПУ ХК	57,851.7	48,952.4	84.6%	46.0	2019.02.19	2019.04.04	2019.05.20-нд олгов
19	AIC	Ард даатгал ХК	1,263.4	631.8	50.0%	25.3	2019.02.19	2019.03.15	2019.06.17-нд олгов
20	GHC	Ган хийц ХК	20.3	12.1	59.7%	50.0	2019.02.19	2019.03.22	2019.10.01-с
21	HUV	Хөвсгөл геологи ХК	107.4	14.4	13.4%	100.0	2019.02.19	2019.04.03	2019.04.29-с
22	HNS	Хөвсгөл хүнс ХК	11.3	2.6	23.4%	10.0	2019.02.19	2019.04.03	2019.05.15-с
23	TAL	Талын гал ХК	255.9	34.7	13.6%	50.0	2019.02.25	2019.03.26	2019.07.19-нд олгов
24	BRC	Барилга корпораци ХК	1,311.0	40.1	3.1%	985.0	2019.02.26	2019.03.18	2019.03.18
25	UBH	Улаанбаатар хивс ХК	235.6	48.6	20.6%	120.0	2019.02.26	2019.03.18	2019.05.31-ний дотор
26	DSS	Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК	11.5	11.4	99.2%	1.1	2019.03.01	2019.03.21	2019.07.02-с
27	ADL	Адуунчулуун ХК	547.1	409.7	74.9%	130.0	2019.03.11	2019.04.03	2019.07.26-нд олгов
28	TEE	Тээвэр дархан ХК	22.3	81.7	365.5%	500.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
29	ERS	Монгол алт ХК	6.3	39.9	631.2%	150.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
30	TTL	Таван толгой ХК	52,858.1	44,923.4	85.0%	853.0	2019.04.26	2019.04.01	2019.06.11-нд олгов
31	EER	Ариг гал ХК	449.3	109.4	24.3%	32.5	2019.04.26	2019.03.27	2019.09.30-ны дотор
32	HRM	Гермес центр ХК	481.3	447.7	93.0%	5.7	2019.08.15	2019.09.02	2019.09.12-с

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн 2019 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тойм

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК нь 2019 оны эхний хагас жилд дараах үр дүнд хүрлээ. Үүнд:

- Хувьцааны анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаагаар нийт 376.9 сая ширхэг хувьцааг 82.3 тэрбум төгрөгөөр, ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаагаар 79.8 мянган ширхэг үнэт цаасыг 7.9 тэрбум төгрөгөөр тус тус арилжиж, нийт 90.2 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий арилжаа хийсэн байна. Энэхүү арилжааг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12.5 тэрбум төгрөгөөр буюу 16.1 хувиар өссөн байна.
- Зах зээлийн үнэлгээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.83%-аар өсөж, 2.6 их наяд төгрөгт хүрлээ.
- МХБ нь хагас жилийн хугацаанд хамгийн олон буюу 4 компанийн үнэт цаасыг шинээр бүртгэж, анхдагч зах зээлд нийт 42.5 тэрбум төгрөгийн арилжаа хийсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад даруй 3 дахин өссөн үзүүлэлт боллоо.
- Бүртгэлтэй компаниудын үүргийн хэрэгжилтийг хангуулах үүднээс хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлээгүй, арилжаа нь зогссон 22 компанийг бүртгэлээс хасав.
- Хөрөнгийн зах зээлийн талаарх олон нийтийн мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх үүднээс нийт 5 аймагт нээлттэй өдөрлөг зохион байгуулж, 7,000 гаруй иргэдийг хамрууллаа.
- Санхүүгийн үзүүлэлтийн хувьд нийтдээ 994.4 сая төгрөгийн орлого олж, 716.9 сая төгрөгийн зардал гаргаснаар нийт 277.4 сая төгрөгийн цэвэр орлоготой ажилласан ба МIT цогц системийн ашиглалтын зардал болон элэгдэл, хорогдолд нийт 482.1 сая төгрөгийн зардлыг хуримтлуулж тооцсоноор санхүүгийн тайландаа татварын өмнөх байдлаар 204.6 сая төгрөгийн алдагдлыг хүлээн зөвшөөрөөд байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт орлого 25.3%-аар, арилжааны шимтгэлийн орлого 34.6%-аар, хураамж үйлчилгээний хөлс 24.6%-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

“Таван толгой” ХК 2019 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангаа танилцууллаа

Монголын Хөрөнгийн Бирж (МХБ)-ийн 1-р ангилалд бүртгэлтэй “Таван толгой” ХК 2019 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангаа 2019 оны 8-р сарын 16-ны өдөр олон нийтэд нээлттэй танилцууллаа. Тайлант хугацаанд:

- 1.1 сая тонн нүүрс олборлон борлуулж, 123.7 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 36.7 хувиар өссөн үзүүлэлт болжээ. Цэвэр ашгийн хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 19 хувиар өсөж, 23 тэрбум төгрөгт хүрлээ.
- Нүүрс борлуулалтын бүтцийн хувьд 53 хувь нь коксжих нүүрс, 23 хувь нь сул коксжих, 7 хувь нь коксжих чанаргүй нүүрс, үлдсэн хувь нь дотоод зах зээлд борлуулсан нүүрс тус тус эзэлж байна. Борлуулалтын орлого нэмэгдэж цэвэр ашиг өсөхийн зэрэгцээ уурхайн уур геологийн нөхцөл байдлаас шалтгаалан олборлолтын өртөг өссөн байдалтай байна.
- Эхний хагас жилийн байдлаар улс, орон нутгийн төсөвт 38.9 тэрбум төгрөгийг төвлөрүүлжээ.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

“Ард санхүүгийн нэгдэл” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд

“Ард Санхүүгийн Нэгдэл” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 8-р сарын 9-ний өдрийн 19/11 тоот тогтоолын дагуу эчнээ санал хураалт явуулахаар болсон байна.

Эчнээ санал хураалтаар шийдвэрлэх асуудал: “Ард санхүүгийн нэгдэл” ХК-ийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг томилох тухай.

Эчнээ санал хураалтанд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр: 2019 оны 8-р сарын 31-ний өдөр.

Эчнээ санал хураалт явуулах хугацаа: 2019 оны 9-р сарын 2-ны өдрөөс 10-р сарын 11-ний өдөр хүртэл.

Эчнээ санал хураалтын материалтай танилцах: 2019 оны 8-р сарын 21-ний өдрөөс эхлэн ажлын өдрүүдэд 09:00-18:00 цагийн хооронд Сүхбаатар дүүрэг, Ерөнхий сайд Амарын гудамж-2, Ард санхүүгийн нэгдлийн байр, 2 давхар хаягаар болон үнэт цаасны компаниудад хандана уу.

Зохион байгуулах комисс: Сүхбаатар дүүрэг, Ерөнхий сайд Амарын гудамж-2, Ард санхүүгийн нэгдлийн байр, 2 давхар.

Утас: 7707-8080, 9944-1747.

И-мэйл: info@ardholdings.com.

Хувьцаа эзэмшигчид өөрийн биеэр эсвэл итгэмжлэгдсэн төлөөлөгчөөрөө дамжуулан өөрийн харилцдаг үнэт цаасны компанид хандан санал авах хуудас бөглөх замаар эчнээ санал хураалтанд оролцох боломжтой.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж



“ЛэндМН ББСБ” ХК 2019 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангаа танилцууллаа

Монголын Хөрөнгийн Бирж (МХБ)-ийн 1-р ангилалд бүртгэлтэй “ЛэндМН ББСБ” ХК 2019 оны эхний хагас жилийн санхүү, үйл ажиллагааны тайлангаа МХБ дээр 2019 оны 8-р сарын 16-ны өдөр олон нийтэд нээлттэй танилцууллаа. Тайлант хугацаанд тус компани нь цахим зээлийн болон төлбөр тооцооны үйлчилгээний цар хүрээг нэмэгдүүлэх зорилт тавин ажилласан бөгөөд дараах голлох үр дүнд хүрсэн байна. Үүнд:

- “LendMn open platform”-ийг олон нийтэд танилцуулж, онлайн дэлгүүр, хямдралын купон, олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, хандивын системийг аппликейшндээ шинээр нэвтрүүлжээ.
- Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад гэрээт харилцагчийн тоо 2.5 дахин, олгосон зээлийн тоо 4.6 дахин, олгосон зээлийн дүн 5 дахин тус тус өсжээ.
- Цэвэр ашгийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад даруй 2 дахин өсөж, 2.56 тэрбум төгрөгт хүрлээ.
- Хувьцааны арилжааны хувьд өдөрт дунджаар 12.6 сая төгрөгийн хувьцаа МХБ-ээр дамжин арилжигдсан нь нийт арилжааны үнийн дүнгийн 8.48%-тай тэнцэж байна.
- Цаашид тус компани нь БНСУ-ын зах зээлд хадгаламжийн бичиг гаргах замаар хувьцаагаа арилжихаар төлөвлөж байгаа тухай мэдэгдлээ.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

Хятадын коксжих нүүрсний импорт 18.3%-аар өсөв

Хятадын гангийн үйлдвэрлэгчид татан авалтаа нэмэгдүүлж байгаагаас үүдэн тус улсын коксжих нүүрсний импорт 7-р сард өсөлттэй гарчээ. Тодруулбал, өнгөрсөн 7-р сард тус улсын хэмжээнд 7.8 сая тонн коксжих нүүрс импортлосон нь өмнөх оны мөн үеийнхээс 1.7%-аар, өмнөх 6-р сарынхаас 18.3%-аар тус тус өссөн дүнтэй гарсан тухай Хятадын Гаалийн ерөнхий газар мэдээллээ.

Тэр дундаа Австралиас авах коксжих нүүрсний хэмжээ 4.0 сая тоннд хүрсэн нь өмнөх 6-р сарынхаас даруй 40.2%-аар нэмэгдсэн байна. Энэ нь Хятадын ган үйлдвэрлэгчдэд дотоодын гэхээсээ илүүтэй импортын нүүрсний үнэ хямд тусч байгаа нь голлон нөлөөлжээ.

Харин Монголоос авах коксжих нүүрсний импорт 7-р сард 2.6 сая тоннд хүрсэн нь өмнөх 6-р сарынхаас 4.4%-аар буурсан дүнтэй гарсан байна.

Хятад руу хийх Оросын коксжих нүүрсний экспорт 7-р сард 731 мянган тоннд хүрсэн нь 27 орчим хувиар өсжээ. "Аргус Медиа" агентлагийн тайлбарлаж буйгаар Оросын экспорт ийнхүү өссөн нь Австралийн нүүрстэй харьцуулахад үнийн хувьд өрсөлдөхүйц байгаа нь голлон нөлөөлсөн байна.

АНУ, БНХАУ хоорондын худалдааны дайны нөлөөгөөр АНУ-ын нүүрсэнд татвар ногдуулж, үнэ нь нэмэгдсэнээр Хятад сүүлийн хэдэн сар АНУ-аас нүүрс импортлоогүй. Тэгвэл өнгөрсөн 7-р сард Хятад руу хийх АНУ-ын коксжих нүүрсний экспорт 197.6 мянган тоннд хүрчээ.

7-р сард Канадаас 179.5 мянган тонн коксжих нүүрс авсан нь өмнөх сартай нь харьцуулахад 61 орчим хувиар буурсан бол Индонезээс 109 мянган тонн коксжих нүүрс импортлосон байна.

Гэхдээ Хятадын коксжих нүүрсний импорт бага зэрэг өссөн явдал нь 7-р сарын эхнээс авахуулан дэлхийн зах зээлд коксжих нүүрсний үнэ буурсантай шинжээчид холбон тайлбарлажээ. 7-р сард Австралийн дээд ангиллын коксжих нүүрсний дундаж үнэ 182 ам.доллар/тонн байсан нь өмнөх 6-р сарынхаас 7.4%-аар буурсан байна.

Харин эрчим хүчний нүүрсний импортыг авч үзвэл өнгөрсөн 7-р сарын үзүүлэлт 24.4 сая тоннд хүрсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 20%, өмнөх сарынхаасаа 23%-аар тус тус нэмэгджээ. Ийнхүү эрчим хүчний нүүрсний импорт нэмэгдсэн нь тус улсын импортын таналтын улмаас оны сүүл улиралд станцууд нүүрс татан авалт хийхэд хүндрэлтэй байх таамгаас үүдэлтэй юм байна.

Оны эхний 7 сарын байдлаар тус улсын бүх төрлийн нүүрсний импорт нийтдээ 187 сая тонноор хэмжигдэж байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 7%-аар нэмэгдсэн дүнтэй гарлаа.

Эх сурвалж: MongolianMiningJournal.mn

Махны үнэ өссөнд экспорт буруугүй

Монгол, Хятадын Засгийн газар хоорондын комиссын хамтарсан хуралдаан дээр манайхаас экспортлох махны хоригийг цуцлахаар талууд тохиролцоод 14 хоноогүй байхад Монголын Засгийн газрын тэргүүн нь "...Ард түмэн 14 мянган төгрөгөөр кг мах худалдан авч байхад махны экспорт хийгээд хэрэггүй шүү дээ, ер нь бол..." хэмээн мэдэгдлээ.

Гэвч БНХАУ-д мах экспортлоход дотоодын нийлүүлэлт, үнэ ханшид нөлөөлөх хэмжээнд хүрэхгүйг Гаалийн ерөнхий газрын статистик мэдээлэл харуулж байна. Монголын үе үеийн Засгийн газрын тэргүүд урд хөршид айлчлах бүртээ мах экспортлох санал тавьдаг.

2018 онд БНХАУ руу гаргадаг махны экспорт оргилдоо хүрсэн билээ. Тус онд манай улсаас БНХАУ-д хонь, ямааны 24 тонн мах экспортлож, 68.5 мянган ам.доллар, мөн адууны мах 29.4 мянган тонныг нийлүүлж, 58.6 сая ам.долларын орлого олжээ.

Тэгвэл махны экспортод хориг тавьсан 2019 онд зөвхөн адууны махыг БНХАУ руу нийлүүлсэн бөгөөд энэ оны эхний хагас жилийн байдлаар 9.6 мянган тонныг 18 сая ам.доллароор экспортлосон байна.

Ингээд 2018 болон 2019 оны экспортын дүнгээс харахад БНХАУ манайхаас ихэвчлэн адууны мах авах сонирхолтой байгаа нь харагддаг.

Тэгвэл бидний хүнсний хэрэгцээнд адууны мах төдийлэн жин дардаггүй атлаа яагаад хомсдол үүсч, махны үнэ 14,000 төгрөгт хүрэв. Үхэр, хонь, ямааг хүнсэндээ зонхилж хэрэглэдэг монголчууд адууны махыг идэр есийн хүйтэн орсон үед хаа нэг иддэг билээ.

Тэгэхээр махны хомсдол, үнийн өсөлтөд БНХАУ руу гаргасан махны экспорт хамааралгүй болж таарч байна. Иймд Ерөнхий сайдын хэлсэн шиг салбарын яам нь ажлаа зөв зохион байгуулж, нөөцийн махаа хүртээмжтэй хийгээд чанартай бэлдэж чадахгүй байгаа, эсвэл ямар нэгэн үл үзэгдэгч этгээд дотоодын зах зээлийг зориудаар эвдээд байгаа.

Өнгөрсөн хаврын мах "магнаг" болсон гол шалтгаан нь нөөцийн мах бэлдэх ажлыг салбарын яам тун муу хийсэнтэй холбоотой. ХХААХҮЯ ч үүнийгээ хүлээн зөвшөөрч, гаргасан алдаагаа дахин давтахгүй хэмээн мэдэгдсэн.

Улаанбаатар хотын хүн амын хаврын улирлын махны хэрэгцээ дунджаар 12.2 мянган тонн гэсэн тооцоо байдаг. Гэтэл 2019 оны хавар дээрх дүнгээс гурав дахин бага мах бэлтгэсэн нь махны үнийг тэнгэрт хадах нөхцөлийг бүрдүүлсэн юм. Тендерт ялсан компаниуд махаа цаг хугацаанд нь нийлүүлж чадаагүй. Тиймээс хариуцсан яам, хяналт тавих үүрэгтэй байгууллагууд эдгээр компаниудад хариуцлага хүлээлгэж, махны нийлүүлэлтийг таслахгүй байх талаар дорвитой арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

Эх сурвалж: ZGM.mn

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдал баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.